

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Баттулга* Б.НАРАНТУЯА



АЖИЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 11-р сарын 01-ний өдөр Дугаар ___

Улаанбаатар хот

2017-11-30

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас: Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "Захиалагч тал" гэх/, түүнийг төлөөлж, Төслийн ажлын дарга, Ч. Баттулга

Нөгөө талаас: Иргэн Жанлавын Эрдэнэ-Очир /цаашид "Гүйцэтгэгч тал" гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь Зайн сургалтын платформ дээр цахим-Эх баригч, нярайн эмч нарын сургалтын хэсгийг нэмж шинэчлэх ба Эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, нярайн эмч нарын тасралтгүй сургалтыг цахим системээр дамжуулан орчин үеийн шинэ мэдээллийг хүргэх ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 2.1. Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1-д заасан ажлыг 2017 оны 11-р сарын 01-ны өдрөөс 2017 оны 12-р сарын 15-ний өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.
- 2.2. Гүйцэтгэгч тал гэрээний хүчинтэй хугацаанд ажлыг гүйцэтгэхдээ өдрийн 8 цаг, долоо хоногийн 40 цаг ажиллана.
- 2.3. Дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

а.Талууд харилцан тохиролцсоноор,

б.Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачлагаар

ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

- 3.1. Гэрээт ажлын хөлсийг хоёр сарын 1 500 000 /нэг сая таван зуун мянга/-н төгрөгөөр тогтоов.
- 3.2. Гэрээ байгуулагдсан өдөр нийт ажлын хөлсний 50 хувь буюу 750 000 /долоон зуун тавин мянга/-н төгрөгийг Гүйцэтгэгч талын Худалдаа хөгжлийн банк 410026085 тоот дансанд шилжүүлнэ.

- 3.3. Ажлын хөлсний үлдэгдэл 50 хувь буюу 750 000 /долоон зуун тавин мянга/-н төгрөгийг Гүйцэтгэгч талын гаргасан ажлын гүйцэтгэлийн тайланг үндэслэн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Худалдаа хөгжлийн банкны 410026085 тоот дансанд шилжүүлнэ.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. Захиалагч нь гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2017 оны 12-р сарын 15-ны дотор Гүйцэтгэгч талаас хүлээн авч, дүгнэнэ.
- 4.2. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлаар мэдээ, мэдээлэл авах, санал, хүсэлт, гомдол гаргах, ажлын чанарт шаардлага тавьж ажиллана.
- 4.3. Ажлын явц, гүйцэтгэлийг хянаж, ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг шаардах.
- 4.4. Гүйцэтгэгч талд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах компьютер, тоног төхөөрөмж, бичиг баримт болон холбогдох бусад мэдээллээр хангах.
- 4.5. Гүйцэтгэгч талын буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлүүлэх, гүйцэтгэж буй ажлын чанар, доголдлыг арилгуулахаар шаардлага тавих.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1. Гэрээний дагуу гүйцэтгэх ажилд шаардагдах материал, техник хэрэгслийг Захиалагч талаас гаргуулан авах.
- 5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг Захиалагч талд нөхөн төлнө.
- 5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад ямар нэгэн байдлаар задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 5.4. Гэрээний хүчинтэй хугацаанд энэхүү гэрээгээр хэрэгжүүлж буй ажил болон ижил төстэй ажлыг өөр бусад байгууллагад хэрэгжүүлэх, зохион байгуулахыг хатуу хориглоно.
- 5.5. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдтэй хамтран баг бүрдүүлэн гүйцэтгэж болох бөгөөд багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Гүйцэтгэгч тал хуваарилж, холбогдох тайлан тооцоог өөрөө хариуцна.
- 5.6. Энэхүү гэрээний 5.5 дахь хэсэгт заасан багийн ажлын гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт, мэдээ, тэмдэглэлийг Захиалагч талд гарган өгч, тайлагнана.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 6.1. Гэрээний үүрэг хэрэгжих явцад Талуудын хамтын ажиллагааны ёс зүйг эрхэмлэн байгууллагын нэр хүнд болон түүнд хамаарах бусад үнэт зүйлсийг хүндэтгэж ажиллана.
- 6.2. Талууд хамтын ажиллагааны явцад олж авсан нууцад хамаарах аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар хортойгоор буруугаар ашиглах болон гуравдагч этгээдэд задруулахыг хатуу хориглоно.
- 6.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүтнээр нь биелүүлээгүй, санаатай болон санамсаргүй үйлдсэн буруутай үйл ажиллагаанаас нөгөө

талдаа учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас захиалагч буюу гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгэх боломжгүй болбол нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

НАЙМ. БАТАЛГАА

- 8.1. Гэрээний дагуу талуудаас гаргаж өгсөн болон гаргаж өгөх бүх баримт бичиг, мэдээлэл, баталгаа нь үнэн зөв бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал нөхцөл байдлыг орхигдуулаагүй.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ


- 9.1. Гэрээтэй холбогдон үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд эв зүйгээр зохицуулахыг эрмэлзэх бөгөөд ингэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 10.2. Гэрээ нь адил хүчинтэй хоёр хувь үйлдэгдсэн бөгөөд Талууд тус бүрт нэг нэг хувь хадгалагдана. Талууд гэрээг хувилж тараахыг хориглоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА


Ч. БАТТУЛГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ж.ЭРДЭНЭ-ОЧИР

